

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-6
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	7-12

---

<b>1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	7-12
---	------

---

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны  
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 31 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Д.Ганмаа;

Чөлөөтэй: Ш.Бямбасүрэн, М.Ганхүлэг, Б.Найдалаа, Б.Түвшин, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, А.Ганбаатар.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа бусад асуудлын материал ирээгүй байгаа тул хойшлуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3

Бүгд: 17

82.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хойшлуулахаар тогтов.

**Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Боловсролын яамны Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Туул, Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч Б.Авид, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд

*нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, О.Саранчулуун, С.Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “шинжилгээний байгууллагын” гэснийг “шинжилгээ, судалгааны ажлын” гэж, мөн заалтын 19<sup>1.1</sup> дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “ажлын тайланг” гэж өөрчилж, “мэдээллийн” гэсний өмнө “цахим” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	3
Бүгд:	18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.2</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.2</sup>.Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	4
Бүгд:	18

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.3</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.3</sup>.Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	3
Бүгд:	18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.4.Энэ хуулийн 31.5 дахь хэсэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.9, 42.10 дахь хэсэгт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 4  
Бүгд: 19  
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 23.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 3  
Бүгд: 19  
84.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 4  
Бүгд: 19  
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 5  
Бүгд: 19  
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Л.Энхнасан:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 4

Бүгд: 19  
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Л.Энхнасан:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3.8 дахь заалтыг бүхэлд нь хасаж, мөн зүйлийн “дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй” гэснийг “доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 4  
Бүгд: 19  
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 5  
Бүгд: 20  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Л.Энхнасан:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 6  
Бүгд: 20  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 24 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 55 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 31 минут.

## **ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Л.Энхнасан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн ирсэн байна. Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51,7 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэж ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн ирсэн байна. Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн байна. Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн байна. Хэн үлдчихэв. Ганбатын Хосбаяр гишүүн ирсэн байна. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Ирц ингээд 55,2 боллоо. Нарантуяа-Нара гишүүн орж ирж байна.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Уянга, Рэгдэл, Хосбаяр нарын гишүүдээс 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2 дугаар асуудал бусад гэсэн байгаа. Хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт орсон бусад гэсэн асуудлын материал ирээгүй учраас энэ асуудлыг бол хэлэлцэхийг хойшлуулъя. Энэ асуудлыг хойшлуулахаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 82,4 хувиар 2 дугаар асуудал хойшиллоо. Санал хураалт явуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй байна.

**Улсын Их Хурлын гишүүн Уянга, Рэгдэл, Хосбаяр нарын гишүүдээс 2025 оны 7 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Байнгын хорооны хуралд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулна уу.

Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Туул Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Авид Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч, Бат-Эрдэнэ Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга.

Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Сархадын Зулпхар танилцуулна. Зулпхар гишүүний микрофоныг нээнэ үү.

**С.Зулпхар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, О.Саранчулуун, С.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Ажлын хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар дараах зарчмын саналыг ажлын хэсгийн гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9-д заасны дагуу та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

1.Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллуулахаар;

2.Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод байлгахгаар;

3.Хууль хоорондын зөрчилтэй болон агуулгын хувьд давхацсан зарим заалтыг тухайлбал, төслийн 23.5 дахь хэсэг нь 19<sup>1</sup> дүгээр зүйлтэй агуулгын хувьд давхацсаныг хасахаар, мөн хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэхэд дээрх хууль бүхэлдээ үйлчлэхгүй гэсэн агуулга нь мөн төсөлд заасан төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад тендерийн болон гүйцэтгэлийн баталгааны зүйл хамаарахгүй гэсэн агуулгатай зөрчилтэй байсныг зөрчлийг арилгаж 3.3.8 дахь заалтыг хасахаар;

4.Хуулийн дагаж мөрдөх хугацааг ердийн журмаар хэрэгжихээр зэрэг саналыг гаргасан болно.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д “Байнгын хороо хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэнэ.” гэж заасан байгаа.

Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс саналтай.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “шинжилгээний байгууллагын” гэснийг “шинжилгээ, судалгааны ажлын” гэж, мөн заалтын 19<sup>1.1</sup> дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “ажлын тайланг” гэж өөрчилж, “мэдээллийн” гэсний өмнө “цахим” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Ариунзаяа, Баатархүү, Бум-Очир, Галбадрах, Ганмаа, Саранчулуун, Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалтад бэлдье. 15 гишүүн дэмжиж, 87,3 саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.2</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.2</sup>.Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Шууд хураачхаж болох юм уу. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 77,8 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.3</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.3</sup>.Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 15 гишүүн дэмжиж, 83.3 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.4.Энэ хуулийн 31.5 дахь хэсэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.9, 42.10 дахь хэсэгт хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсэг дарга Зулпхар. Микрофоныг нь өгье.

**С.Зулпхар:** Ажлын хэсгийн дарга Байнгын хорооны гишүүдэд бас бид өчигдөр энэ санал хураасны дараа ажлын хэсэг хууль санаачлагч нартай дахиж уулзсан юм байгаа юм. Тэгээд уулзах явцад бол энэ 23.4 дэх хэсэг бол 31.5 дахь хэсэгтэй бол агуулгын хувьд давхацсан зүйл байгаа. Анх бол яах вэ хууль санаачлагчийн хувьд бол энэ тендерийн 2 баталгаанаас чөлөөлөх асуудлыг үүгээр давхар зохицуулъя гэдэг ийм санал орж ирсэн. Тэгээд дахиж бид энийг ярилцсан.

2 дугаарт ажлын хэсгийн явцад бас энэ бол агуулга давхцаж байна. Логикийн зөрчил гарах юм байна. Хууль хэрэглээний явцад бас ахиад маргаан үүсгэнэ гэдэг ийм саналууд гарсан. Тийм учраас бид бол өчигдөр ярьсны дагуу ажлын хэсгийн гишүүд энэ саналыг бол татаж авч байгаа юм. Энэ санал дээр санал хураалгахгүйгээр, татаж авч байна. Энэ асуудлыг бид нар хойно Тендерийн тухай хуулиар зохицуулсан байгаа гэдгийг бас энд хэлье. Үүний дагуу бас энийг татаж авах санал хураалгаж өгнө үү.

**Л.Энхнасан:** Тэгэхээр ажлын хэсгийн саналын дагуу татаж авсанд тооцлоо.

Энэ 4 дүгээр заалттай холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гарсан байна. Саналыг уншъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Рэгдэл.

Рэгдэл гишүүний микрофоныг өгье.

**Д.Рэгдэл:** Бид нар ажлын хэсгийн зүгээс 23.4 дээр бол нэлээн өөр томъёололтой заалт оруулж өгсөн юм байгаа юм. Тэгээд ажлын хэсэг хуралдаад ер нь энэ өөрчлөлтийг бүхэлд нь авч хэлэлцэх замдаа 23.4-ийг өөрчилж томъёолох нь зүйтэй юм байна гээд өөрчилж томъёолсон. Бид нарын анхны санал бол би та нарт уншаад өгчихье.

Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарласан сонгон шалгаруулалтад энэ хуулийн 3.1.11-д заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгэх тохиолдолд тендерийн болон гүйцэтгэлийн баталгаанаас чөлөөлнө гээд орсон.

Тэгээд дараа нь үүнийг өөрчилсөн томъёолол болохоор та бүхэн харж байгаа байх. Энэ хуулийн 31.5 дахь хэсгийн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.9, 42.10 дахь хэсэгт хамаарахгүй гэхэж байгаа юм. Тэгэхдээ зэрэг энэ 23.4-ийн шинэ томъёоллоор томъёолсон энэ заалт Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 31.5 дахь заалттайгаа логик зөрчил үүсгээд явчхаж байгаа юм. 31.5-даа. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд одоо энэ заалтыг хэрэгжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчөөр ажил, үйлчилгээ худалдан авах энэ хууль хамаарахгүй гэсэн заалттай байхад тэрнээс нь тасалж авч байгаад 2 заалтад хамаарахгүй гээд дахиад оруулах зохимж муутай юм байна гэж ингэж үзээд, ерөөсөө энэ 23.4-ийг татаад авчихсан нь зохимжтой байна гэсэн санал л оруулж байгаа юм. Зөрчилд оруулахгүйн тулд гэсэн үг.

**Л.Энхнасан:** Тэгэхээр төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 15 гишүүн дэмжиж, 78,9 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 23.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 16 гишүүн дэмжиж, 84,2 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсэг саналтай.

6.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 15 гишүүн дэмжиж, 78,9 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Гишүүд саналгүй байна. Ажлын хэсгийн саналтай.

7.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 73,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт. 15 гишүүн буюу 78,9 хувиар дэмжигдлээ.

Хоёр дугаарт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсэг саналтай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3.8 дахь заалтыг бүхэлд нь хасаж, мөн зүйлийн “дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй” гэснийг “доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналаар санал хураалт. 15 гишүүн буюу 78,9 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 15 гишүүн буюу 75 хувиар дэмжигдлээ. 15 гишүүн дэмжиж, 75 хувиар дэмжигдлээ.

2 дугаарт, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух,

зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна. Санал хураалт явж дууслаа.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсэг саналтай.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. 14 гишүүн дэмжиж, 70 хувиар дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралд Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлыг өндөрлөснийг мэдэгдье.

14.55 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*